



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 12 сарын 16 өдөр

Дугаар A/156

Улаанбаатар хот

Салбар дундын хамтарсан багийн
бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан багийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажиллах журмыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

2.Салбар дундын хамтарсан багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, шаардагдах төсвийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба (Ж.Буянбат)-нд үүрэг болгосугай.

Б.ЭНХБАЯР

131801720

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2025 оны 12 дугаар сарын 16 өдрийн
А/156 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДЭД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
САЛБАР ДУНДЫН ХАМТАРСАН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд: Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн ахлах прокурор

Нийслэлийн прокурорын газрын Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих 2 дугаар хэлтсийн дарга

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хууль тогтоомж, бодлого, төлөвлөлт хариуцсан шинжээч

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн харилцаа, Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын газрын хөдөлмөрийн хяналтын ахлах мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Осол гэмтэл, хүчирхийллийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газрын Сэтгэцийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Гадаад харилцааны яамны Консулын газрын Нэгдүгээр нарийн бичгийн дарга

Тагнуулын ерөнхий газрын ажилтан

Эрүүгийн цагдаагийн албаны Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн эрүүгийн ахлах мөрдөгч

Мөрдөн байцаах албаны Хүүхдийн эсрэг болон хүүхдээс үйлдсэн гэмт хэрэг мөрдөх хэлтсийн эрүүгийн мөрдөгч

Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн боомтын газрын Шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга

Гадаадын иргэн, харьяатын газрын Зөрчил шалган шийдвэрлэх газрын хяналтын улсын байцаагч

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын улсын бүртгэгч

Шүүх шинжилгээний ерөнхий газрын Шүүх анагаах ухааны шинжилгээний газрын Шүүх сэтгэцийн шинжилгээний тасгийн дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Нийгмийн халамжийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилтийн газрын дарга

Боловсролын ерөнхий газрын Суралцагчийн хөгжлийн газрын дарга

Хууль зүйн туслалцааны төвийн Мэргэжил арга зүйн хэлтсийн салбар хариуцсан мэргэжилтэн

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байрны зохицуулагч

“Хүйсийн тэгш эрхийн төв” ТББ-ын хөтөлбөрийн менежер

Нарийн бичгийн дарга:

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын Хүүхэд, гэр бүлийн хамгааллын бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2025 оны 12 дугаар сарын 16 өдрийн
А/15.6 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДЭД ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ САЛБАР ДУНДЫН ХАМТАРСАН БАГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтад заасан Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтарсан баг (цаашид “Хамтарсан баг” гэх)-ийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, эрх хэмжээ, үйл ажиллагаа, санхүүжилт, урамшуулалтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Хамтарсан баг нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, тэгш хүртээмжтэй байх, хохирогч, тэр дундаа хүүхэд төвтэй арга барилыг баримтлах, хохирогчийн бие махбод, сэтгэл зүйн гэмтэл, хохирлыг харгалзах, дахин хохироохгүй байх, хүний эрхийг дээдлэх, ялгаатай байдлыг хүндэтгэх, хувь хүний нууцыг хамгаалах, салбар дундын хамтын ажиллагааг хангах зарчмыг баримтална.

1.3. Хамтарсан баг нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйл, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-д заасан хохирогч хүүхдийн талаар мэдээлэл хүлээн авах, илрүүлэх, аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийх, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх, гэр бүлд нь эргэн нэгтгэх зэрэг шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах, үзүүлж буй үйлчилгээний үр дүнг хянаж, тайлагнана.

Хоёр. Хамтарсан багийн зохион байгуулалт, чиг үүрэг

2.1. Хамтарсан баг хүүхэд хамгаалал, нийгмийн халамж, хөдөлмөрийн харилцаа, улсын бүртгэл, эрүүл мэнд, боловсрол, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн байгууллага, прокурор, өмгөөллийн байгууллага, хууль сахиулах байгууллага, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

2.2. Хамтарсан баг хүүхдийг хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос урьдчилан сэргийлэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах, түүний нэр төр, аюулгүй байдлыг хангах, шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлэх ажлыг уялдуулан зохицуулна.

2.3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг улсын хэмжээнд хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд тухайн орон нутгийн хүүхэд, гэр бүл хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хэрэгжүүлэхэд хамтарсан баг оролцогч талуудыг нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

2.4. Хамтарсан багийн бүрэлдэхүүнийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

2.5. Хамтарсан баг ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд гүйцэтгэх чиг үүргээр хохирогчид үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх дэд багт хуваагдаж болно.

2.6.Хамтарсан багийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал бөгөөд ээлжит хурлыг улирал тутам зохион байгуулна.

2.7.Үйл ажиллагааны шуурхай байдлыг хангах үүднээс хамтарсан багийн хурлыг цахим хэлбэрээр явуулж болно. Цахим хэлбэрээр явуулж байгаа тохиолдолд хурлын нууцлалыг хадгалах арга хэмжээ авах ба гишүүнээс бусад этгээд хуралд оролцох боломжгүй байхаар зохион байгуулна.

2.8.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхэд илэрсэн, хэрэг хянан шийдвэрлэх байгууллага, албан тушаалтнаас хүсэлт ирсэн, тухайн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх шаардлагатай тохиолдолд хамтарсан багийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна. Ээлжит бус хурлыг тухайн хэлэлцэх асуудалтай холбогдох чиг үүрэг бүхий гишүүдийн хүрээнд хуралдуулж болно.

2.9.Хамтарсан багийн нийт гишүүдийн олонх нь оролцсоноор хурлыг хүчинтэйд тооцно.

2.10.Хамтарсан баг асуудлыг хурлаар хэлэлцэж шийдвэрлэх ба шийдвэр нь хурлын тэмдэглэлээр баталгаажна. Хурлын тэмдэглэлд тухайн хурлаар хэлэлцсэн асуудлын холбогдох баримт бичгийн эх хувийг хавсаргана.

2.11.Хамтарсан багийн хурлаас гарах шийдвэр, албан бичгийг баталгаажуулахад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх)-ны хэвлэмэл хуудас, тэмдэгийг хэрэглэнэ.

2.12.Хамтарсан багийн хурлын тэмдэглэлийг нарийн бичгийн дарга хөтөлж, хамтарсан багийн ахлагч, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарж баталгаажуулна.

2.13.Хамтарсан баг дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.13.1.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь хэсэг заасан журмын дагуу хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, ерөнхий боловсролын хичээл, сургалтад хамруулах, гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүнд үзүүлэх үйлчилгээнд холбон зуучлах, шаардлагатай удирдлага зохицуулалтаар хангаж ажиллах;

2.13.2.Хамтарсан багийн чиг үүрэгт хамаарахгүй асуудлаар тодорхой шийдвэр гаргуулахаар холбогдох байгууллага, албан тушаалтанд Ажлын албаар дамжуулан хүсэлт гаргах;

2.13.3.Хүн худалдаалах гэмт хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх талаар хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой мэдээлэл солилцож, хамтран ажиллах;

2.13.4.Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр бусад орны холбогдох байгууллагатай хамтран ажиллах саналыг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэдэх Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлд /цаашид “Дэд зөвлөл” гэх/ гаргаж шийдвэрлүүлэх, хууль, журамд заасны дагуу хамтран ажиллах;

2.13.5.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний мэдээллийн сан бүрдүүлэх;

2.13.6.Хамтарсан багийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хурлаараа хэлэлцэн баталж, биелэлтийг хагас жил тутам тайлагнах;

2.13.7.Хуульд заасан бусад чиг үүрэг.

2.14.Хохирогч хүүхдэд үйлчилгээ үзүүлэхдээ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.4-т заасан журмыг баримтална.

2.15.Хүүхдийг улсын хилээр нэвтрүүлэхдээ хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталсан журмыг баримтална.

2.16.Хамтарсан багийн ахлагч дараах үүрэгтэй байна:

2.16.1.Хамтарсан багийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нэгдсэн арга зүй, удирдлагаар хангах;

2.16.2.Хамтарсан багийн ээлжит болон ээлжит бус хурлыг товлон хуралдуулах, хэлэлцэх асуудлыг батлах, хурлын шийдвэрийг албажуулах;

2.16.3.Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хяналт тавих, хамтарсан багийн үйл ажиллагааны тайланг хурлаар хэлэлцэж, Дэд зөвлөлд танилцуулах;

2.16.4.Хамтарсан багийн хурлын шийдвэр, холбогдох саналыг Дэд зөвлөлд уламжилж, шийдвэрлүүлэх;

2.16.5.Хамтарсан багийн гишүүдэд чиг үүрэгт нь хамаарах асуудлаар үүрэг өгч, биелэлтэд хяналт тавих;

2.16.6.Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллах.

2.17.Хамтарсан багийн нарийн бичгийн дарга дараах үүрэгтэй байна:

2.17.1.Хамтарсан багийн өдөр тутмын үйл ажиллагааны зохион байгуулалт, зохицуулалтыг хариуцах;

2.17.2.Хамтарсан багийн ээлжит болон ээлжит бус хуралд оролцох гишүүдэд хурлын тов, хэлэлцэх асуудлын талаар 3-аас доошгүй ажлын өдрийн өмнө урьдчилан мэдэгдэж, тэднээс санал авч нэгтгэх;

2.17.3.Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд гишүүд, оролцогч байгууллагуудаас санал авч боловсруулан хамтарсан багийн ахлагчид танилцуулах, хурлаар хэлэлцэн батлуулах;

2.17.4.Хамтарсан багийн үйл ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулж, хамтарсан багийн ахлагчид танилцуулах.

2.18.Хамтарсан багийн гишүүд холбогдох хууль тогтоомжид зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.18.1.Хамтарсан багийн гишүүд мэргэжлийн ёс зүйг баримтлан, ажил үүргээ хариуцлагатай гүйцэтгэж, хурал, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох;

2.18.2.Хамтарсан багийн ээлжит бус хурлыг хуралдуулах саналыг гаргах;

2.18.3.Хамтарсан багийн хурлаар хэлэлцэх асуудалд санал оруулах, хэлэлцүүлэх;

2.18.4.Хамтарсан багийн ахлагчийн эзгүйд түүний үүргийг ахлагчийн эрх олгосноор гүйцэтгэх;

2.18.5.Хариуцсан чиглэлийн хүрээнд хамтарсан багийн чиг үүрэгт хамаарах үйл явдал, нөхцөл байдал (кейс) илэрсэн тохиолдолд шуурхай танилцуулж, шийдвэр гаргуулах;

2.18.6.Шаардлагатай тохиолдолд хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр өөрийн чиг үүрэгт хамаарах холбогдох судалгаа, мэдээллийг хамтарсан багийн хуралд танилцуулах;

2.18.7.Хамтарсан багийн хурлаас гарсан шийдвэр, хамтарсан багийн ахлагчаас өгсөн үүргийн хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хуралд танилцуулах;

2.18.8.Хамтарсан багийн үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг хангах үүднээс харилцан мэдээлэл солилцож, шуурхай ажиллах, салбар дундын уялдаа холбоог хангах.

Гурав.Хамтарсан багийн үйл ажиллагаа, үйлчилгээ

3.1.Хамтарсан багийн гишүүн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, хохирогч байж болзошгүй хүүхдийн талаарх мэдээллийг хүлээн авсан, өөрөө илрүүлсэн бол хамтарсан багт нэн даруй танилцуулж, холбогдох хууль, журамд заасан үйлчилгээнд холбох бөгөөд хамтарсан баг удирдлага зохион байгуулалтаар ханган, биелэлтэд хяналт тавина. Шаардлагатай тохиолдолд шууд үйлчилгээ үзүүлнэ.

3.2.Хамтарсан багийн ахлагч тухайн мэдээлэлтэй танилцан, хамтарсан багийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, шуурхай арга хэмжээ авна.

3.3.Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

3.4.Хамтарсан багаас хүүхдийг хүн худалдаалахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1.Олон улсын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, олон нийтэд таниулах үйл ажиллагааг зохион байгуулах;

3.4.2.Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлах, хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

3.4.3.Хүүхдийг хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургагч багш бэлтгэх, хамтарсан багийн гишүүд, хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах албан тушаалтныг мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах, зөвхөн хүүхдэд төдийгүй тэдний эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн гишүүдэд чиглэсэн хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалт, мэдээллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах.

Дөрөв.Хамтарсан багийн үйл ажиллагааны тайлан, санхүүжилт, урамшуулал

4.1.Салбар дундын хамтарсан баг хохирогч хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний тайланг хагас жил тутам, хяналт шинжилгээ үнэлгээний тайланг жил тутам Дэд зөвлөлд танилцуулна.

4.2.Хамтарсан багийн үйл ажиллагааг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйл, мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт заасны дагуу холбогдох байгууллагын жил бүрийн төсөвт тусгасан зардал болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

4.3.“Аргачлал, зардлын норматив батлах тухай” Засгийн газрын 2024 оны 236 дугаар тогтоолоор батлагдсан аргачлал, нормативын дагуу хамтарсан багийн үйл ажиллагаанд шаардагдах зардлын жишгийг баримтлан хамтарсан багийн үйл ажиллагааны зардал болон гишүүдэд олгох урамшууллыг тооцох бөгөөд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасны дагуу хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний жил бүрийн төсвийн багцад тусган санхүүжүүлнэ.

4.4.Үйл ажиллагааны санхүүжилт, зарцуулалтад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл хяналт тавьж, тайланг хагас, бүтэн жилээр гаргуулан авч дүгнэнэ.

4.5.Хамтарсан багийн үйл ажиллагаанд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, мөн хуулийн 6 дугаар зүйлд заасан Дэд зөвлөл болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журамд заасны дагуу Ажлын алба өөрсдийн эрхлэх чиг үүргийн хүрээнд хяналт тавина.

Тав.Мэдээллийн нууцлал

5.1.Хамтарсан багийн гишүүн үйл ажиллагааныхаа явцад олж мэдсэн хүний хувийн болон эмзэг мэдээлэл, байгууллагын нууц, төрийн болон албаны нууцыг хамгаалах үүрэгтэй.

5.2.Хамтарсан баг үйлчилгээ үзүүлэх явцад хамтран ажиллаж буй хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагатай энэ журмын 5.1 дэх хэсэгт заасан үндэслэл үүсвэл нууцын гэрээ заавал байгуулна.

5.3.Энэ журмын 5.2-т заасан гэрээ байгуулаагүйгээс хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг олон нийтэд задруулсан тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад хандана.

5.4.Хамтарсан багийн гишүүн үүрэгт ажлаас гарах, өөрчлөгдөх үед мэдээллийг нууцлах, задруулахгүй байх үүрэг хүлээх ба тухайн албан тушаалд шинээр томилогдсон хүн уг гишүүний үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.

Зургаа.Бусад зүйл

6.1.Хамтарсан багийн шийдвэр, гишүүний үйл ажиллагаа хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох хуулийн дагуу гомдол, нэхэмжлэл гаргаж болно.

6.2.Энэ журмыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--oOo--